



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР
ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2022 оны 06 сарын 09 өдөр

Дугаар 06

Хэрлэн сум

Галшар сумын Ерөнхий боловсролын сургуулийн захиралын сул орон тоонд томилуулахаар нэр дэвшүүлэх тухай

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 5.7, 3.5, 3.5.4 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 25 дугаар тогтоолоор баталсан “Төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийг сонгон шалгаруулах журам”-ын 7.2, 7.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийн сонгон шалгаруулалтад хамгийн өндөр оноо (60,5) авч тэнцсэн Бямбажавын Мөнх-Оргилыг Галшар сумын Ерөнхий боловсролын сургуулийн захиралын сул орон тоонд томилуулахаар нэр дэвшүүлсүгэй.

2. Нэр дэвшигч Б.Мөнх-Оргилыг тухайн албан тушаалд томилсон шийдвэрийг ажлын 14 өдрийн дотор албан бичгээр ирүүлэх шаардлагатайг Галшар сумын Засаг дарга (Ө.Сарантуяа)-д зөвлөсүгэй.

3. Энэхүү тогтоолыг Галшар сумын Засаг даргад хүргүүлж, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Салбар зөвлөлийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ш.Эрдэнэжаргал)-д даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР